

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/24/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН СОГТУУРАХ, МАНСУУРАХ ДОНТОЙ ӨВЧТӨНГ
АЛБАДАН ЭМЧЛЭХ АЛБАДАН ХӨДӨЛМӨР ХИЙЛГЭХ ГАЗРЫН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: tsaranchimeg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Төлбөрийн акт.....	15
4.3 Албан шаардлага.....	Error! Bookmark not defined.
4.4 Зөвлөмж	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, Имэйл: tuv@audit.gov.mn

2022.02.22 № 01/42
танай _____ -ны № _____ -т

СОГТУУРАХ, МАНСУУРАХ ДОНТОЙ
ӨВЧТӨНГ АЛБАДАН ЭМЧЛЭХ,
АЛБАДАН ХӨДӨЛМӨР ХИЙЛГЭХ
ГАЗРЫН ДАРГА Б.БАТТУЛГА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ
19020209

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	712,142,283.58	282,391,916.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	30,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	30,000.00
3121	Төгрөг	-	30,000.00
31211	Төрийн сангийн харилцах	-	30,000.00
34	УРЬДЧИЛГАА	255,000,000.00	66,225,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	255,000,000.00	66,225,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	457,142,283.58	216,136,916.50
351	Түүхий эд материал	202,114,532.27	93,032,845.73
35110	Тусгай зориулалттай материал	14,230,662.50	17,868,830.00
35130	Эм боох материал	187,883,869.77	75,164,015.73
354	Хангамжийн материал	255,027,751.31	123,104,070.77
35410	Бичиг хэргийн материал	521,560.00	405,133.50
35420	Аж ахуйн материал	70,664,197.20	42,427,186.32
35440	Түлш, шатах тослох материал	757,560.00	510,600.00
35450	Барилгын засварын материал	749,000.00	1,540,000.00
35460	Хүнсний материал	182,335,434.11	78,221,150.95
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	979,931,769.74	913,812,459.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	979,931,769.74	913,812,459.26
392	Биет хөрөнгө	876,999,515.18	811,576,347.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	624,539,594.11	624,539,594.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	(51,605,697.37)	(80,126,469.23)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	87,733,333.00	76,833,333.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(18,654,629.63)	(23,476,851.91)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	372,535,670.70	371,428,445.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	(148,289,167.24)	(180,437,218.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,173,570.35	61,196,770.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	(39,033,158.74)	(39,981,254.96)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног	1,600,000.00	1,600,000.00
393	Биет бус хөрөнгө	102,932,254.56	102,236,111.30
39301	Програм хангамж	4,987,692.31	4,987,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,055,437.75)	(4,751,581.01)
39303	Бусад биет бус хөрөнгө	102,000,000.00	102,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,692,074,053.32	1,196,204,375.76
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,375,000.00	30,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,375,000.00	30,000.00
413	Өглөг	3,375,000.00	30,000.00
4136	Бусад өглөг	3,375,000.00	30,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	30,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,688,699,053.32	1,196,174,375.76
51	Засгийн газрын хувь оролцоо	1,688,699,053.32	1,196,174,375.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	512,937,694.90	512,937,694.90
51101	Өмч: - төрийн	512,937,694.90	512,937,694.90
512	Хуримтлагдсан үр дүн	888,281,491.30	395,756,813.74
51210	Өмнөх үеийн үр дүн	888,281,491.30	888,281,491.30
51220	Тайлант үеийн үр дүн	-	(492,524,677.56)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	287,479,867.12	287,479,867.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,692,074,053.32	1,196,204,375.76

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Төгсгөлөөр/ Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	712,142,283.58	282,391,916.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	30,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	30,000.00
3121	Төгрөг	-	30,000.00
31211	Төрийн сангийн харилцах	-	30,000.00
34	УРЬДЧИЛГАА	255,000,000.00	66,225,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	255,000,000.00	66,225,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	457,142,283.58	216,136,916.50
351	Түүхий эд материал	202,114,532.27	93,032,845.73
35110	Тусгай зориулалттай материал	14,230,662.50	17,868,830.00
35130	Эм боох материал	187,883,869.77	75,164,015.73
354	Хангамжийн материал	255,027,751.31	123,104,070.77
35410	Бичиг хэргийн материал	521,560.00	405,133.50
35420	Аж ахуйн материал	70,664,197.20	42,427,186.32
35440	Түлш, шатах тослох материал	757,560.00	510,600.00
35450	Барилгын засварын материал	749,000.00	1,540,000.00
35460	Хүнсний материал	182,335,434.11	78,221,150.95
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	979,931,769.74	913,812,459.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	979,931,769.74	913,812,459.26
392	Биет хөрөнгө	876,999,515.18	811,576,347.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	624,539,594.11	624,539,594.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	(51,605,697.37)	(80,126,469.23)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	87,733,333.00	76,833,333.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(18,654,629.63)	(23,476,851.91)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	372,535,670.70	371,428,445.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	(148,289,167.24)	(180,437,218.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,173,570.35	61,196,770.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	(39,033,158.74)	(39,981,254.96)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	1,600,000.00	1,600,000.00
393	Биет бус хөрөнгө	102,932,254.56	102,236,111.30
39301	Програм хангамж	4,987,692.31	4,987,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,055,437.75)	(4,751,581.01)
39303	Бусад биет бус хөрөнгө	102,000,000.00	102,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,692,074,053.32	1,196,204,375.76
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,375,000.00	30,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,375,000.00	30,000.00
413	Өглөг	3,375,000.00	30,000.00
4136	Бусад өглөг	3,375,000.00	30,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	30,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,688,699,053.32	1,196,174,375.76
51	Засгийн газрын хувь оролцоо	1,688,699,053.32	1,196,174,375.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон	512,937,694.90	512,937,694.90
51101	Өмч: - төрийн	512,937,694.90	512,937,694.90
512	Хуримтлагдсан үр дүн	888,281,491.30	395,756,813.74
51210	Өмнөх үеийн үр дүн	888,281,491.30	888,281,491.30
51220	Тайлант үеийн үр дүн	-	(492,524,677.56)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	287,479,867.12	287,479,867.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,692,074,053.32	1,196,204,375.76

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

						/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	512,937,694.90	288,707,635.92	(13,001,992.64)		788,643,338.18
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	(1,227,768.80)	1,227,768.80		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	512,937,694.90	287,479,867.12	(11,774,223.84)	-	788,643,338.18
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн			900,055,715.14		900,055,715.14
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	512,937,694.90	287,479,867.12	888,281,491.30	-	1,688,699,053.32
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	512,937,694.90	287,479,867.12	1,788,337,206.44	-	2,588,754,768.46
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	512,937,694.90	287,479,867.12	888,281,491.30	-	1,688,699,053.32
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			(492,524,677.56)		(492,524,677.56)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	512,937,694.90	287,479,867.12	395,756,813.74	-	1,196,174,375.76

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,649,899,112.00	1,026,292,387.19
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	215,000.00	240,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	215,000.00	240,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	215,000.00	210,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	215,000.00	210,000.00
120009	Бусад орлого	-	30,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,649,684,112.00	1,026,052,387.19
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,649,684,112.00	1,006,052,387.19
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,649,684,112.00	1,006,052,387.19
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт	-	20,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,649,899,112.00	1,026,262,387.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,649,899,112.00	1,026,262,387.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,649,489,112.00	1,025,632,387.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	583,668,400.00	645,827,433.27
210101	Үндсэн цалин	410,214,700.00	390,298,900.00
210102	Нэмэгдэл	172,453,700.00	253,310,800.00
210104	Урамшуулал	1,000,000.00	2,217,733.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	22,772,400.00	21,056,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,772,400.00	21,056,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,000,000.00	89,690,600.00
210301	Гэрэл, цахилгаан	53,000,000.00	39,000,000.00
210302	Түлш, халаалт	49,000,000.00	47,690,600.00
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	3,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,926,400.00	15,909,500.00
210401	Бичиг хэрэг	518,700.00	728,700.00
210402	Тээвэр, шатахуун	10,925,800.00	11,409,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,156,300.00	1,156,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,210,600.00	2,615,000.00
2105	Нормативт зардал	519,497,900.00	99,255,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	240,362,700.00	67,658,600.00
210502	Хоол, хүнс	249,150,000.00	31,596,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,872,700.00	141,733,299.92
210601	Багаж, техник, хэрэгсэл	32,159,800.00	44,670,399.92
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	296,300.00	296,300.00
210604	Урсгал засвар	6,416,600.00	96,766,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	357,870,112.00	7,756,054.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	355,806,400.00	5,151,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	784,000.00	784,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	290,912.00	293,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	918,200.00	918,200.00
210807	Газрын төлбөр	40,600.00	579,454.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,881,200.00	4,403,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,323,800.00	3,845,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	557,400.00	557,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	410,000.00	630,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	410,000.00	630,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	630,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	30,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	30,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн	-	30,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/ төгрөгөөр /			
		Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,649,899,112.00	1,649,899,112.00	1,026,300,700.00	1,026,262,387.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,649,899,112.00	1,649,899,112.00	1,026,300,700.00	1,026,262,387.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,649,489,112.00	1,649,489,112.00	1,025,670,700.00	1,025,632,387.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	583,668,400.00	583,668,400.00	645,865,700.00	645,827,433.27
210101	Үндсэн цалин	410,214,700.00	410,214,700.00	390,298,900.00	390,298,900.00
210102	Нэмэгдэл	172,453,700.00	172,453,700.00	253,310,800.00	253,310,800.00
210104	Урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	2,256,000.00	2,217,733.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,772,400.00	22,772,400.00	21,056,800.00	21,056,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,772,400.00	22,772,400.00	21,056,800.00	21,056,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,000,000.00	105,000,000.00	89,690,600.00	89,690,600.00
210301	Гэрэл, цахилгаан	53,000,000.00	53,000,000.00	39,000,000.00	39,000,000.00
210302	Түлш, халаалт	49,000,000.00	49,000,000.00	47,690,600.00	47,690,600.00
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	3,000,000.00	3,000,000.00	3,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,926,400.00	17,926,400.00	15,909,500.00	15,909,500.00
210401	Бичиг хэрэг	518,700.00	518,700.00	728,700.00	728,700.00
210402	Тээвэр, шатахуун	10,925,800.00	10,925,800.00	11,409,500.00	11,409,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,156,300.00	1,156,300.00	1,156,300.00	1,156,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,210,600.00	5,210,600.00	2,500,000.00	2,615,000.00
2105	Нормативт зардал	519,497,900.00	519,497,900.00	99,255,500.00	99,255,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	240,362,700.00	240,362,700.00	67,658,600.00	67,658,600.00
210502	Хоол, хүнс	249,150,000.00	249,150,000.00	31,596,900.00	31,596,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,872,700.00	38,872,700.00	141,733,300.00	141,733,299.92
210601	Багаж, техник, хэрэгсэл	32,159,800.00	32,159,800.00	44,670,400.00	44,670,399.92
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	296,300.00	296,300.00	296,300.00	296,300.00
210604	Урсгал засвар	6,416,600.00	6,416,600.00	96,766,600.00	96,766,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	357,870,112.00	357,870,112.00	7,756,100.00	7,756,054.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	355,806,400.00	355,806,400.00	5,151,200.00	5,151,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	784,000.00	784,000.00	784,000.00	784,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	290,912.00	290,912.00	293,200.00	293,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00	30,000.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	918,200.00	918,200.00	918,200.00	918,200.00
210807	Газрын төлбөр	40,600.00	40,600.00	579,500.00	579,454.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,881,200.00	3,881,200.00	4,403,200.00	4,403,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,323,800.00	3,323,800.00	3,845,800.00	3,845,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	557,400.00	557,400.00	557,400.00	557,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	410,000.00	410,000.00	630,000.00	630,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	410,000.00	410,000.00	630,000.00	630,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	410,000.00	630,000.00	630,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,649,978,100.00	1,649,978,100.00	1,006,300,700.00	1,006,339,012.81
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,649,763,100.00	1,649,763,100.00	1,006,090,700.00	1,006,129,012.81
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,649,763,100.00	1,649,763,100.00	1,006,090,700.00	1,006,129,012.81
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	215,000.00	215,000.00	210,000.00	210,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	215,000.00	215,000.00	210,000.00	210,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				30,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	47.00	47.00	47.00	47.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00	2.00	2.00
620002	Гүйцэтгэх ажилтан	35.00	35.00	35.00	35.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	10.00	10.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	20,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	20,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	20,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	20,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	8,100,000.00
210604	Урсгал засвар	-	11,900,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	20,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	20,000,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		30,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 01/69 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь архинд донтох өвчтэй этгээдийг албадан эмчлэх чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн байгууллага юм.

Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/200 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналт шалгалт явуулах ажлын хэсгийг байгуулж шалгалт явуулах хуваарийг баталсан байна.

Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын дотоод хяналтын ажлын хэсэг нь тайлант онд 11 ажил төлөвлөснөөс эмнэлгийн, сэтгэл зүйн, санхүүгийн, харуул хамгаалалтын, хүний нөөц, дотоод ажлын албаны, короно вирус цар тахалтай тэмцэх гэсэн 6 ажлын чиглэлээр тус тус хяналт шалгалт явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар тухай бүр хугацаатай үүрэг өгч хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх хяналт, шалгалт, аюулгүй ажиллагааны газраас шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 1,920,288.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 28,804.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 21,603.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 15,736.9 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 13,067.4 мянган төгрөгөөр буурсан байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 11,802.7 мянган төгрөгөөр тогтоогдсон байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд улсын төсвөөс 1,006,090.7 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 20,000.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 210.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 22,831.2 мянган төгрөг нийт 1,049,131.9 мянган төгрөг өмнөх оноос 871,156.5 мянган төгрөгөөр буюу 45,4 хувиар буурсан байна.

Зардал:

Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 1,049,131.9 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 1,026,330.7 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 1,026,262.4 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100140312070 тоот дансанд 2021 онд 1,216,262.4 мянган төгрөгийн орлого, 1,006,262.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 30.0 мянган төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100140312402 тоот дансанд 20,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрч, 20,000.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	30.0	(30.0)
Авлага	-	-	-
Урьдчилгаа	255,000.0	66,225.0	188,775.0
Бараа материал	457,142.3	216,136.9	241,005.4
Үндсэн хөрөнгө	979,931.8	913,812.5	66,119.3
Нийт хөрөнгө	1,692,074.1	1,196,204.4	495,869.7
Өр төлбөр	3,375.0	30.0	3,345.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,688,699.1	1,196,174.4	492,524.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,692,074.1	1,196,204.4	495,869.7

Бараа материалын дансны үлдэгдэл 216,136.9 мянган төгрөг болж 241,005.4 мянган төгрөгөөр буурсан нь Ар Гүнт дэх сайн дурын архины эмнэлэгт хэвтэн

эмчлэгдэж буй эмчлүүлэгчдийн эм, хоолны зардалд зарцуулсан, бусад ангид хүнсний, материал шилжүүлснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 913,812.5 мянган төгрөг болж 66,119.3 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө акталснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 25,121.4 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 12,550.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, акталсан 36,655.5 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,196,174.4 мянган төгрөг болж 492,524.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 7,702,084.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 7,702,084.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 6,675,822.0 мянган төгрөгөөр бууруулж улсын төсвөөс 1,026,262.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын шинэ барилга 5,373,891.3 мянган төгрөг, цалин 362,966.4 мянган төгрөг, Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 82,045.6 мянган төгрөг, норматив зардал 663,428.7 мянган төгрөг эд хогшил урсгал засварын зардал 90,181.7 мянган төгрөгөөр зардлыг бууруулсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,026,300.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,006,090.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, туслах үйл ажиллагааны орлогоос 210.0 мянган төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,006,090.7 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого, 210.0 мянган төгрөгийн туслах үйл ажиллагааны орлогыг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,006,262.4 мянган төгрөгийг зарцуулж, 38.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,026,262.4 мянган төгрөг буюу 99,99 хувьтай зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь тайлант онд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 20,000.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, өрөө тохижуулах урсгал зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар улсын төсвийн хөрөнгөөр 17,021.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 8,100.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан, ШШГЕГ-аас 12,550.0 мянган төгрөг шилжүүлэн хүлээн авч санхүүгийн тайланд тайлагнасан байна.

Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/580, А/228 тоот хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан согтуурах, мансуурах донтой хүнийг сайн дурын эмчилгээнд хамруулахад зарцуулах 181,250.0 мянган төгрөгийн эм тариа, 160,711.0 мянган төгрөгийн хоол хүнс, 29,985.2 мянган төгрөгийн зөөлөн эдлэлийг 2020 онд бэлтгэсэн. Ковид 19 цар тахал гарсантай холбоотойгоор хөл хориотой үед энэ үйл ажиллагаа хэвийн явагдаагүйгээс 7 сард 40,9 сард 70,11 сард 60 хүнд, хүн тус бүрд 21 хоногийн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Иймд 2021 оны 11 дүгээр сарын 11-ны байдлаар хадгалалтын хугацаа 2021 оны 11 дүгээр сараас 2022 оны 1 сард дуусах 40,397.5 мянган төгрөг гурил, будааг бусад анги салбарт Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын даргын баталсан хуваарийн дагуу үнэ төлбөргүй шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Согтуурах, мансуурах донтой хүнийг сайн дурын эмчилгээнд хамруулахад зарцуулах эм тариа болон хоол хүнсний материалын солилцоо хийсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна. Тус байгууллага Шилэн дансанд хөрөнгө худалдан авах тухай гэрээнүүдийг болон 5,000.0 мянган төгрөгөөс дээших орлого, зарлагын гүйлгээг бүрэн оруулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан 20,000.0 мянган төгрөгийг бусад хууль тогтоомжийн хүрээнд зарцуулан тайлагнасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах, бараа материалыг өөрийн эзэмшлийн газар байршуулах, шилэн дансны цахим сайтад мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж мэдээлэх, 2 албан шаардлага 1 зөвлөмжийг 100.0% хэрэгжүүлэн ажиллаж Төв аймгийн Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 01/981 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ар гүнт дэх сайн дурын эмнэлгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 52,255.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4,606.1 мянган төгрөгийн материаллаг, 47,649.5 мянган төгрөгийн материаллаг бус алдааг илрүүлж, 4,606.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, төсвийн төлөвлөлттэй холбоотой 47,649.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Албан шаардлага

1. Хүнсний ногооны хорогдлыг тогтоосон нормоос хэтрүүлэн 3635.7 тн буюу 1,636.1 мянган төгрөгийн төмсийг акталж төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэснийг болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

2. Ахмадын баяраар эмчлүүлэгчдийн хоол хүнсний материалаас гарын бэлэг болгон 2,970.0 мянган төгрөгийн гурил будааг зарлага гаргаж төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын 6 дугаар хавсралтын 210502 -хоол, хүнс гэсэн ангилалд "хууль тогтоомжийн дагуу хоолоор хангах үйлчилгээтэй тухайлбал, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн хоолны зардал"-ыг ангилан бүртгэнэ. Энэ нь тухайн байгууллагын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой эрх бүхий байгууллагаас батлагдсан норм, нормативын дагуу төлөвлөгөө болон гүйцэтгэлийн хоолны зардлын нийт хэмжээ нь тухайн үйлчилгээг авсан хүний тоотой шууд уялдсан байна гэснийг болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлын 210102 кодтой нэмэгдлийн зардлаас нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 47,649.5 мянган төгрөгийг олгосон зөрчил илэрсэн. Сангийн сайдын 2014 оны 55 тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын 6 дугаар хавсралтын 210102- нэмэгдэл цалинд “Төрийн албаны тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу олгож байгаа нэмэгдэл цалингууд” багтана гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Дараа жилийн төсвийн төслийг бэлтгэхдээ Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын 6 дугаар хавсралтын 214305- Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад холбогдох хууль, тогтоомжийн дагуу 5 жил тутамд нэг удаа дэмжлэг үзүүлэхэд шаардагдах зардлыг энэ ангилалд бүртгэнэ гэснийг баримтлан төсөв, төлөвлөгөөг боловсруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д / д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар	3	52,255.6	0	0	0	0	2	4,606.1	1	47,649.5